



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Төслийн удирдах хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан "Экспортыг дэмжих төсөл"-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын 1 дүгээр хэсгийн А.2 заалт, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ний өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 10.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг."Экспортыг дэмжих төсөл"-ийг бодлого, үйл ажиллагааны удирдамжаар хангах, төслийн хэрэгжилтийг хянах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах, ерөнхий хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Төслийн удирдах хороог Хавсралт ёсоор баталсугай.

Хоёр.Төслийн хэрэгжилтийг хянаж, бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог хангаж ажиллахыг Төслийн удирдах хороо /Б.Нямаа/-нд үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Сангийн сайдын 2017 оны 2 сарын 20-ны
өдрийн 68 дугаар тушаалын Хавсралт

Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн

Удирдах хорооны дарга:

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн
бичгийн дарга

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
дарга

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын
дарга

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн
танхимын Гадаад харилцаа, худалдаа, хөрөнгө
оруулалтын газрын дарга

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн
танхимын Экспортлогчдын зөвлөлийн нарийн
бичгийн дарга

"Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ний
гүйцэтгэх захирал

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Экспортыг дэмжих төслийн менежер
